

ЭМЧЛҮҮЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ЭМИЙН ЗААВАР

НООФЕН 100 мг Ууж хэрэглэх уусмал бэлтгэхэд зориулсан нунтаг

НООФЕН 500 мг Ууж хэрэглэх уусмал бэлтгэхэд зориулсан нунтаг

Фенибут

Эмийн бэлдмэлийг хэрэглэхээс өмнө хэрэглэгчдэд зориулсан эмийн заавартай заавал танилцана уу. Энэхүү заавар нь Танд зориулсан чухал мэдээлэл агуулж байгаа.

Энэхүү зааварт бичигдсэний дагуу, эсвэл эмч болон эм зүйчийн зөвлөсөнийг ягштал баримтлан эмийн бэлдмэлийг хэрэглэх хэрэгтэй.

- Хэрэглэх зааврыг заавал хадгалах хэрэгтэй. Учир нь түүнийг дахин унших хэрэгтэй болж магадгүй.
- Хэрвээ Танд ямар нэг асуулт гарвал эм зүйч болон эмчлэгч эмчээсээ зөвлөгөө аваарай.
- Хэрэв ямар нэг гаж нөлөөний урвал илрэх, эсвэл шинж тэмдэг нь улам хүчтэй болох, ялангуяа энэхүү зааварт бичигдээгүй урвал илэрвэл энэ талаар эм зүйч болон эмчлэгч эмчдээ мэдэгдэнэ үү. Энэхүү заавар нь илэрч болзошгүй бүх гаж нөлөөний талаар, тэр дотроо эмийн зааварт бичигдээгүй гаж нөлөөний урвалуудад хамаатай. 4-р хэсгийг харна уу.
- Хэрэв таны бие сайжрахгүй, эсвэл улам муудаад байвал та эмчлэгч эмчдээ хандах хэрэгтэй.

Эмийн зааврын агуулга:

1. Ноофен бэлдмэл гэж юу вэ, түүнийг ямар зорилгоор хэрэглэдэг вэ?
2. Ноофен бэлдмэлийг хэрэглэхийн өмнө сайтар анхаарах ёстой чухал мэдээлэл
3. Ноофен бэлдмэлийг хэрхэн хэрэглэх вэ?
4. Илэрч болзошгүй гаж нөлөө
5. Ноофен бэлдмэлийг хадгалах нөхцөл
6. Савлагааны агуулагдахуун ба бусад мэдээлэл

1.Ноофен бэлдмэл гэж юу вэ, түүнийг ямар зорилгоор хэрэглэдэг вэ?

Ноофен нь айдас, түгшүүр болон тавгүйтлийг бууруулдаг, нойрсолтыг сайжруулж, нистагмын (нүдний алимны хэмнэлтэй, хурдаг хөдөлгөөн) нууц

хугацааг уртасгах болон үргэлжлэх хугацаа, эрчимийг бууруулдаг эмийн бэлдмэл юм. Түүнээс гадна ноофен бэлдмэл нь толгой өвдөх, толгой хүнд оргих, нойр тавгүйтэх, цочромхой болох, сэтгэл зүй тогтворгүй болох зэрэг астенийн шинж тэмдгийг (биеийн болон мэдрэлийн ядаргаа, биеийн ерөнхий ядаргаа) багасгана. Ноофен нь оюуны үйлийн чадавхийг нэмэгдүүлнэ. Энэхүү эмийн бэлдмэл нь анхаарал, ой тогтоолт, урвалд хариу өгөх хурд болон нягт нямбай байдлыг сайжруулдаг. Сэтгэл санаа тогтворгүй болон ядаргаа, астенитай өвчтөнд Ноофен бэлдмэл нь хэт тайвшруулах таагүй нөлөө үзүүлэлгүйгээр биеийн ерөнхий байдлыг сайжруулах, дур сонирхол, санаачлага, идэвхийг нэмэгдүүлэх үйлдэл үзүүлдэг.

Ноофеныг дараах заалтаар хэрэглэнэ:

- Мэдрэл сульдал, түгшүүрийн байдлын үед (айдас, түгшүүр, тавгүйтэл), ахмад настай эмчлүүлэгчдэд – шөнө нойргүйдэх, шөнийн айдас, түгшүүрийн үед, мэс заслын өмнөх стрессийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэнэ,
- Хүүхдэд – ээрэх, тик таталтын эмчилгээнд хэрэглэнэ,
- Меньерын өвчний үед (дотор чихний өвчин), төрөл бүрийн гаралтай, тэнцвэрийн эрхтний үйл ажиллагааны алдагдалтай холбоотой толгой эргэлт,
- Кинетозоос (усан онгоц, нисэх онгоц зэрэг хөдөлгөөнт төхөөрөмжийн улмаас үүссэн дотор муухайралт, бөөлжилт, сульдах, тэнцвэрийн эрхтний үйл ажиллагааны алдагдал зэргээр илэрдэг эмгэг байдал),
- Архи хэтрүүлэн уух хам шинжийг (архинаас хамааралтай) бууруулах үед нэмэлтээр хэрэглэнэ.

2.Ноофен бэлдмэлийг хэрэглэхийн өмнө сайтар анхаарах ёстой чухал мэдээлэл

Дараах тохиолдолд Ноофеныг хэрэглэж болохгүй:

- Хэрэв та фенибут болон энэ эмийн найрлага дахь бусад бэлдмэлд (6-р хэсэгт дурьдсан) харшилтай бол,
- Хэрэв та жирэмсэн эсвэл хүүхдээ хөхөөр хооллодог бол,
- Хэрэв танд фенилкетонури байдаг бол (зөвхөн Ноофен 500мг ууж хэрэглэх уусмал бэлтгэх зориулалттай нунтагт л хамаарна)

Анхааруулга ба авах арга хэмжээ

Дараах тохиолдолд Ноофен бэлдмэлийг хэрэглэхийн өмнө эмчтэйгээ ярилцах хэрэгтэй:

- хэрэв та ходоод эсвэл/болон нарийн гэдэсний шархлаа өвчтэй бол. Энэ тохиолдолд эмчлэгч эмч тань эмийн тунг бууруулж болзошгүй,
- хэрэв эмийн бэлдмэлийг удаан хугацаагаар хэрэглэж байгаа бол эмч таныг цусны дэлгэрэнгүй болон элэгний үйл ажиллагааны сорил хийлгэхийг зөвлөж болно,

Ноофен ба бусад эмийн бэлдмэл

Хэрэв та өөр ямар нэг эмийн бэлдмэл хэрэглэж байгаа, саявтархан хэрэглэсэн, эсвэл хэрэглэхээр төлөвлөж байгаа бол энэ талаараа эмч болон эм зүйчдээ мэдэгдэх хэрэгтэй.

Энэ эмийн бэлдмэлийг сэтгэц нөлөөт өөр эмийн бэлдмэлтэй хэрэглэх тохиолдолд Ноофен болон хавсран хэрэглэж буй эмийн тунг бууруулах хэрэгтэй.

Ноофен нь ховсдолт, мансууруулах үйлдэлтэй эм, солиорлын эсрэг бэлдмэл болон паркинсоны эсрэг бэлдмэлийн үйлчлэх хугацааг уртасгаж, хүчийг нэмэгдүүлнэ.

Жирэмсэн болон хөхүүл үеийн хэрэглээ

Ноофен бэлдмэлийг жирэмсэн болон хөхүүл үед хэрэглэж болохгүй (**Дараах тохиолдолд Ноофеныг хэрэглэж болохгүй** заалтыг харна уу). Хэрэв та өөрийгөө жирэмсэн гэж бодож байгаа, эсвэл жирэмслэхээр төлөвлөж байгаа бол энэ эмийн бэлдмэлийг хэрэглэхийн өмнө эмч, эсвэл эм зүйчээс зөвлөгөө авна уу.

Ноофен нөхөн үржихүйд нөлөөлдөг талаар мэдээлэл байхгүй байна.

Авто тээврийн хэрэгсэл жолоодох болон машин механизм ажиллуулах

Энэ эмийн бэлдмэлийг хэрэглэж байхдаа нойрмоглох, төв мэдрэлийн тогтолцооны талаас таагүй байдал мэдэрдэг эмчлүүлэгч энэ төрлийн гаж нөлөөний урвалууд илэрч байгаа үед авто тээврийн хэрэгсэл жолоодох, машин механизм ажиллуулахгүй байх хэрэгтэй.

Ноофен бэлдмэлийн найрлага дахь нэгдлүүдийн талаар чухал мэдээлэл

Ноофен 500мг ууж хэрэглэх зориулалттай уусмал бэлтгэх нунтаг нь сахар орлуулагч аспартам агуулдаг. Фенилкетонуритай өвчтөнд түүнийг хэрэглэж болохгүй.

3.Ноофен бэлдмэлийг хэрхэн хэрэглэх вэ?

Энэ эмийн бэлдмэлийг эм хэрэглэх зааварт бичсэнийг ягштал баримтлан эмч, эм зүйчийн зөвлөсөний дагуу хэрэглэнэ. Хэрэв танд эргэлзээтэй санагдвал эмч болон эм зүйчээс зөвлөгөө аваарай.

Уутанд агуулагдаж буй нунтагийг тал аяга бүлээн усанд уусгаад хоолны өмнө ууж хэрэглэнэ.

Насанд хүрсэн хүмүүс

Мэдрэл сульдал болон айдас түгшүүрийн байдал

500мг тунгаар өдөрт 1-3 удаа. Шаардлагатай бол хоногийн тунг 2,5г хүртэл ихэсгэж болно. Эмчилгээний ээлж хугацаа 2-3 долоо хоног байдаг. Шаардлагатай бол эмчилгээний ээлж хугацааг 4-6 долоо хоног болгон уртасгаж болно.

Меньерын өвчний үед (дотор чихний өвчин), төрөл бүрийн гаралтай, тэнцвэрийн эрхтний үйл ажиллагааны алдагдалтай холбоотой толгой эргэлт

Халдварын гаралтай тэнцвэрийн эрхтний үйл ажиллагааны алдагдал болон Меньерын өвчний сэдрэлийн үед:

- 500мг тунгаар өдөрт 4 удаа, 5-7 хоногийн турш,
- Тэнцвэрийн эрхтний зовиур буурахад эмчилгээг 500мг-аар өдөрт 2-3 удаа, 5-7 хоногийн турш үргэлжлүүлнэ.
- Дараа нь дахиад 5 хоногийн турш өдөрт 1 удаа 500мг-аар хэрэглэнэ.

Өвчин хөнгөн явцтай байгаа тохиолдолд өдөрт 500мг-аар 5-7 хоногийн турш хэрэглэнэ.

Судасны болон гэмтлийн гаралтай тэнцвэрийн эрхтний үйл ажиллагааны алдагдлаас үүссэн толгой эргэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор 500мг-аар өдөрт 1-2 удаа, 12 өдрийн турш хэрэглэнэ.

Кинетозоос урьдчилан сэргийлэх

Кинетозын анхны шинж тэмдэг илрэх (дотор муухайрах) илрэхэд эсвэл таамаглаж буй савлах хөдөлгөөн эхлэхээс нэг цагийн өмнө 500мг тунгаар хэрэглэнэ. Шинж тэмдэг (бөөлжих) илэрсэн тохиолдолд эмийн бэлдмэл үр нөлөө бага үзүүлдэг.

Архины хамаарлын хам шинжийг бууруулах үед нэмэлтээр хэрэглэх

Эхний өдрүүдэд 500мг-аар өдөрт 2-3 удаа болон унтахдаа 500мг, дараа нь тунг үечлэн бууруулна.

Элэгний үйл ажиллагааны алдагдалтай өвчтөн

Элэгний үйл ажиллагааны алдагдалтай өвчтөнд Ноофен бэлдмэлийг өндөр тунгаар хэрэглэхэд элгэнд хортой нөлөө үзүүлж болно. Эмчилгээний үр нөлөөтэй хамгийн бага тунг энэ бүлгийн өвчтөнд хэрэглэх нь зохистой.

Бөөрний үйл ажиллагааны алдагдалтай өвчтөн

Бөөрний үйл ажиллагааны алдагдалтай өвчтөнд Ноофен бэлдмэлийг эмчилгээний тунгаар хэрэглэхэд гаж нөлөө үзүүлэх талаар мэдээлэл байхгүй байна.

Хүүхэд болон өсвөр үеийнхэнд хэрэглэх

Ээрэх болон тик таталт

3-4 насны хүүхдэд: 100мг-аар өдөрт 2 удаа.

5-6 насны хүүхдэд: 100мг-аар өдөрт 2-3 удаа.

7-10 насны хүүхдэд: 100мг-аар өдөрт 3-4 удаа.

11-14 насны хүүхдэд: 200мг-аар өдөрт 2-3 удаа.

3-4 насны хүүхдэд: 100мг-аар өдөрт 2 удаа.

14-өөс дээш насны хүүхдэд: насанд хүрэгсдийн тунгаар хэрэглэнэ.

6 хүртэл насны хүүхдэд нэг удаагийн хамгийн дээд тунг -100мг, 7-10 насны хүүхдэд -200мг, 11-14 насны хүүхдэд – 300мг байна.

Хэрэв танд энэ эмийн бэлдмэлийн тунг хэтэрхий хүчтэй, эсвэл хэтэрхий сул санагдвал эмчлэгч эмчээсээ зөвлөгөө аваарай.

Энэ бэлдмэлийг хэрэглэхэд эмийн бэлдмэлийн тэвчил эсвэл эмийн хамаарал, эмийн бэлдмэлийг гэнэт зогсоосноос үүсэх дутагдлын хам шинж ажиглагдаагүй байна.

Хэрэв Ноофен бэлдмэлийг хэрэглэх ёстойгоос их тунгаар хэрэглэсэн бол
Шинж тэмдэг: нойрмоглох, дотор муухайрах, бөөлжих, толгой эргэх. Хэрэв та хэрэглэх хэмжээнээс их тунгаар Ноофен бэлдмэлийг хэрэглэсэн бол яаралтай эмнэлгийн тусламж авах хэрэгтэй.

Ноофен бэлдмэлийг хэрэглэхээ мартсан бол

Зааврын дагуу эмийн бэлдмэлийг үргэлжлүүлэн хэрэглэх хэрэгтэй. Мартсан тунг нөхөж уухын тулд давхар тунг хэрэглэж болохгүй.

Ноофен бэлдмэлийг хэрэглэхээ зогсоох

Энэ эмийн бэлдмэлийг хэрэглэхэд танд эргэлзээтэй асуудал үүсвэл эмч болон эм зүйчээс зөвлөгөө аваарай.

4.Илэрч болзошгүй гаж нөлөө

Бусад эмийн бэлдмэлийн адил Ноофен гаж нөлөө үзүүлж болох боловч хүн бүрт илрэх албагүй.

Ховор тохиолдох (1000 өвчтөнд 1 хүртэл тохиолдоно):

- Харшлын урвал (арьс улайх, загатнаа).

Тодорхойгүй (байгаа мэдээлэлд тулгуурлан давтамжийг тодорхойлох боломжгүй):

- Нойрмоглох болон дотор муухайрах (эмчилгээний эхэн үед);
- Толгой өвдөх, толгой эргэх (өдөрт 2г-аас дээш тунгаар хэрэглэхэд, тунг бууруулахад гаж нөлөөний урвалууд багасна);
- Элгэнд хортой нөлөө (урт хугацаанд, өндөр тунгаар хэрэглэхэд).

Энэхүү зааварт бичигдээгүй өөр төрлийн гаж нөлөөний урвал илэрсэн тохиолдолд, эсвэл аль нэг гаж нөлөө улам хүндэрч, ноцтой болж байвал эмчид хандаарай.

5.Ноофен бэлдмэлийг хэрхэн хадгалах вэ?

25 °C-ээс дээш хэмд хадгалаж болохгүй.

Үйлдвэрлэгчийн савалгаанд, чийг орохоос хамгаалж хадгална.

Гэрлийн шууд тусгал болон хүүхдийн гар хүрэхээргүй газар хадгална.

Савлагаанд дээрх хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд хэрэглэж болохгүй.

Дуусах хугацаа тухайн сарын сүүлчийн өдрийг заана.

Урсгал ус болон ахуйн хогтой хамт ямар ч эмийн бэлдмэлийг хаяж болохгүй. Цаашид хэрэглэхгүй болсон эмийн бэлдмэлийг хэрхэн хаяж устгах талаар эм зүйчээс зөвлөгөө аваарай. Ийм арга хэмжээ авах нь хүрээлэн байгаа орчныг хамгаалахад тустай.

6.Савлагааны агуулагдахуун ба бусад мэдээлэл

Ноофены найрлага

Идэвхитэй үйлчлэгч бодис нь фенибут юм (Фенибутум).

Ууж хэрэглэх уусмал бэлтгэх зориулалттай нунтаг Ноофен 100мг.

Нэг уутанд 100мг фенибут агуулагдана.

Найрлага дахь бусад бодис (туслах бодис) нь маннитол, тауматин, “Жүржийн Дураром” үнэр оруулагч.

Ууж хэрэглэх уусмал бэлтгэх зориулалттай нунтаг Ноофен 500 мг.

Нэг уутанд 500мг фенибут агуулагдана.

Найрлага дахь бусад бодис (туслах бодис) нь маннитол, аспартам, “Жүржийн Дураром” үнэр оруулагч.

Ноофен бэлдмэлийн харагдах байдал ба уутны агуулагдахуун

Ууж хэрэглэх уусмал бэлтгэх зориулалттай нунтаг Ноофен 100мг.

Шаргалдуу туяатай цагаан, бараг цагаан өнгийн нунтаг. Шар өнгийн агуулагдахуун байж болно.

Ламинатан уутанд (цаас/полиэтилен ялтас/хөнгөн цагаан фольга/полиэтилен ялтас ЭСВЭЛ цаас/ полиэтилен ялтас/хөнгөн цагаан фольга/этилений кополимер ялтас болон акрилийн хүчил) 1г нунтаг агуулагдана.

Хатуу цаасан хайрцагт 15 уут нунтаг, эм хэрэглэх зааврын хамт савлагдсан байна.

Ууж хэрэглэх уусмал бэлтгэх зориулалттай нунтаг Ноофен 500мг.

Шаргалдуу туяатай цагаан, бараг цагаан өнгийн нунтаг. Шар өнгийн агуулагдахуун байж болно.

Ламинатан уутанд (цаас/полиэтилен ялтас/хөнгөн цагаан фольга/полиэтилен ялтас ЭСВЭЛ цаас/ полиэтилен ялтас/хөнгөн цагаан фольга/этилений кополимер ялтас болон акрилийн хүчил) 2,5г нунтаг агуулагдана.

Хатуу цаасан хайрцагт 5 уут нунтаг, эм хэрэглэх зааврын хамт савлагдсан байна.

Үйлдэрлэгч ба борлуулалт хариуцсан байгууллага

JSC "Olainfarm".

5 Rupnicu Str., Olaine, LV-2114, Latvia

Tel.: +371 67013705

Fax: +371 67013777

E-mail: olainfarm@olainfarm.lv